

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2021 ОНЫ ТАЙЛАН**

- Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар
- Эрх бүхий албан тушаалтан 99599658, 88599658
- 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

№	Хөтөлбөрийн танилцуулга хэсэг		
1.	Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, МУ-ын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Дундговь аймгийн Засаг даргын 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2020-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	
2.	Хөтөлбөрийн зорилго	Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх	
3.	Санхүүжилтийн эх үүсвэр	Орон нутгийн хөрөнгө оруулалт	
4.	Хэрэгжүүлэгч байгууллага	Бүх шатны төрийн байгууллага	
5.	Хэрэгжих нийт хугацаа	4 жил	
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p><b>Зорилт 1.</b> шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;</p> <p><b>Зорилт 2.</b> төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p><b>Зорилт 3.</b> төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p><b>Зорилт 4.</b> худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p><b>Зорилт 5.</b> шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах;</p> <p><b>Зорилт 7.</b> авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;</p> <p><b>Зорилт 10.</b> шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх;</p> <p><b>Зорилт 11.</b> Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан шинэлэг ажил;</p>	
7.	Зардал	Төсөв	10.0 сая.төг
		Үүнд:	Төсөв
		1-р үе шат	-
			Гүйцэтгэл
			-

**Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хэсэг**

Төсөл, хөтөлбөрийн зорилт:

Гүйцэтгэлийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөний арга хэмжээ болон аймгийн Засаг даргын 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2020-2023 онуудад хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний заалт бүрээр хүрсэн түвшин, үр дүнгээр тооцон гаргав.

**Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийн хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох.**

Аймаг, сумын удирдлагуудаас нийтийн албанд нэр дэвшүүлсэн 118 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлэн хянуулж, хянуулсан дүгнэлтийг [dundgov.gov.mn](http://dundgov.gov.mn) сайтны Ил тод байдал хэсэгт бүрэн байршуулж ил тод, нээлттэй байдлыг ханган ажилласан.



8. **Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;**

**100 хувь**  
**Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх.**

Тус хугацаанд аймгийн Засаг даргаас нийтийн албанд нэр дэвшүүлсэн 11 этгээд, ын даргаас нэр дэвшүүлсэн 4 этгээд, бусад нэр дэвшүүлсэн 2 хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим хэлбэрээр бүрэн



аймгийн ЗДТГ-дэвшүүлсэн 4 байгууллагаас этгээдийн сонирхлын 100 хувь хянууллаа.

**100 хувь**  
**ХАСУМ-д хавсаргаж хүргүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлтийг оруулах.**

Нийтийн албанд нэр дэвшиж буй этгээдүүдийн албан тушаалын тодорхойлолт, Төрийн албаны салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн тогтоол, ХАСУМ гаргасан баталгааны маягт, нэр дэвшиж буй этгээдийн хянуулах албан бичиг зэрэг холбогдох баримт бичгийг цаасан хэлбэрээр хүргүүлэн, хянуулах ажлыг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу зохион байгуулж хэвшүүллээ.



**70 хувь**  
**Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ хянуулалгүйгээр томилгоо хийсэн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх**


Төрийн албаны удирдах албан тушаалын давхардсан тоогоор 17, гүйцэтгэх албан тушаалын дэс түшмэлийн албан тушаалын сул орон тооны давхардсан тоогоор 91 албан тушаал, туслах түшмэлийн 43 сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлж шалгалтыг 2021 оны 1, 10 дугаар саруудад зохион байгуулж, шалгалтаар 49 ажлын байр

нөхөгдлөө. Дээрх 151 ажлын байрны зарыг [dundgovi.gov.mn](http://dundgovi.gov.mn) сайтны ТАСЗөвлөл талбар, Төрийн албан зөвлөлийн [csc.gov.mn](http://csc.gov.mn)-д байршуулан сурталчилж, иргэдийг мэдээлэл авах боломжийг бүрэн бүрдүүлж, нийтийн албанд дэвшүүлсэн 21 этгээдийн Төрийн албаны салбар зөвлөлийн тогтоолын хамт ХАСУМ-ийг хянуулах ажлыг зохион байгуулж, ХАСУМ-ээ хянуулаагүй томилогдсон Говь-Угтаал сумын ЕБС-ийн сургалтын менежерийг уг ажлаас чөлөөлөв.

70%

### Нийтийн албанд шинээр томилогдсон этгээдийн ХАСХОМ-ийг 30 хоногт хүлээн авч баталгаажуулах.

Тус хугацаанд Нийтийн албанд нэр дэвшсэн 118 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлэн хянуулж, хянуулсан дүгнэлтийг үндэслэн албан тушаалтнуудыг томилсон. Томилогдсон албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд буюу 30 хоногтоо хүлээн авч баталгаажуулах ажлыг зохион байгууллаа.




100 хувь

### Нутгийн захиргааны байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох.

Төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын давхардсан тоогоор 199 сул орон тоо гарсныг [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn) сайтны ТАСЗ хэсэгт, Төрийн албаны зөвлөлийн [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) сайтны Сонгон шалгаруулалт хэсэгт, Төрийн албаны зөвлөлийн самбарт тус байршуулан сурталчилах ажлыг байгууллаа.

Төрийн жинхэнэ анх орох иргэний жагсаалтад бүртгэлтэй 2019 оны 13, 2020 оны оны 101 иргэний шалгалтын дүн, танилцуулгыг жагсаалтаар гарган [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn) цахим сайтад ил тод байршууллаа.


ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР



Төрийн албаны өрнөий шалгалт зохион байгуулагдана.

Төрийн албаны өрнөий шалгалт зохион байгуулагдана. Төрийн албаны өрнөий шалгалт зохион байгуулагдана. Төрийн албаны өрнөий шалгалт зохион байгуулагдана.

Дүрс хэдэн өм хууин төрөөн Мэлэн бэлтгэр, тэжээл, үрэн хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын сонгон шалгаруулалтын зар



салбар тус зохион албанд нөөцийн байгаа 47, 2021

70 хувь

### Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох асуудлыг судлан, гүйцэтгэлийн үнэлгээ хийх.

Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 218 дугаар “Журам батлах тухай” тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 100 дугаар “Аргачлал, загвар батлах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан аргачлалын даргуу 3270 төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хагас,

		<p>бүтэн жилээр үнэлгээний баг гүйцэтгэлийн үнэлгээ хийж, үнэлж дүгнэх ажлыг зохион байгууллаа.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p> <p><b>Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.</b></p> <p>Авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй дараах асуудлуудыг Авлигатай тэмцэх газарт мэдэгдсэнээр Хулд сумын Засаг даргаар ажиллаж байсан Ч.Зоригтбаатарыг нийтийн албанд томилогдох эрхийг 3 жил, Гурвансайхан сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны даргаар ажиллаж байсан Ү.Алимааг нийтийн албанд томилогдох эрхийг 2 жил, Өлзийт сумын Засаг даргаар ажиллаж байсан А.Эрдэнэбатыг нийтийн албанд томилогдох эрхийг 2 жил, Дэлгэрцогт сумын Засаг даргаар ажиллаж байсан Б.Иш-Ёндонг нийтийн албанд томилогдох эрхийг 4 жил, Цагаандэлгэр сумын Засаг дарга Д.Буджавыг нийтийн албанд томилогдох эрхийг 5 жилээр тус тус хасах ял оногдуулан шийдвэрлэсэн байна.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p> <p><b>Авлигын эсрэг хууль тогтоомжийн сургалтанд аймаг, сумын төрийн албан хаагчдыг хамруулах.</b></p> <p>Авлигатай тэмцэх газрын iaас.mn сайтны сургалт бүртгэл хэсэгт Авлигатай тэмцэх газрын сургалтанд хамрагдах нэрсийн жагсаалтад 2 удаа 300, 300 (гурван зуу, гурван зуу) албан тушаалтны мэдээллийг шивж хүргүүлсэн. Мөн тус оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Дундговь, Хөвсгөл аймгийн төрийн байгууллагын албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг сургалт(zoom) буюу Авлига, авлигын шалтгаан, нөхцөл, хор хөнөөл, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдэгдэл, тайлбар гаргах, авлигын гэмт хэргийн тухай ойлголт, Эрүүгийн хууль дахь авлигын гэмт хэргийн зохицуулалт зэрэг сэдвүүдээр зохион байгуулагдсан сургалтанд 300 албан тушаалтныг оролцуулж, тэдний Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар зохих түвшний мэдлэг олгох, өмнө авсан мэдлэгийг баталгаажуулсан үр дүн гарлаа.</p> <p>Мөн 15 сумын ЗДТГ, ИТХ, 128 байгууллагын 218 удирдлага, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч, нягтлан бодогч, Эрх бүхий албан тушаалтан, хэвлэл мэдээллийн ажилтан болон төрийн албан хаагчдыг оролцуулан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн сургалтанд оролцуулсан.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p>
<p><b>Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилгыг хангах чиглэлээр</b></p>		<p><b>Төрийн зарим ажил үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, үйлчилгээг ил тод, нээлттэй болгох.</b></p> <p>Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны ERP удирдлагын нэгдсэн системийг үйл ажиллагаандаа байнга ашиглан шат дамжлагыг бууруулан, ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. Аймгийн нэг цэгийн үйлчилгээний танхимд “Гэрэгэ” киоск машиныг суурилуулан ажиллуулж, уг машинаар төрийн болон төрийн бус 55 байгууллагын 600 гаруй төрлийн үйлчилгээний төлбөрийг төлөх боломжийг бүрдүүлж, уг төхөөрөмжөөр 320 иргэн 10 төрийн байгууллагын төлбөр хураамжийг төвлөрүүлэн үйлчлүүлсэн байгаа нь төрийн</p>

		<p>үйлчилгээний шат дамжлага буурч иргэдийн сэтгэл ханамж дээшлүүлсэн үр дүн гарсан.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p> <p><b>Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн талаарх судалгаа хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах.</b></p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдаас 2021 оны нэгдүгээр сард ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн судалгааг 3 бүлэг, 16 асуулгаар авахад албан хаагчдын ерөнхий сэтгэл ханамж 76,050 хувьтай байсан. Санал асуулгын дүгнэлтэд үндэслэн 3 чиглэлийн хүрээнд 15 арга хэмжээний төлөвлөгөө батлуулан ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх санал асуулгыг 11 дүгээр сард албан хаагчдаас авч дүнг харьцуулахад албан хаагчдын сэтгэл ханамж 4.6 хувиар өссөн үр дүнтэй байна.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p> <p><b>Төрийн байгууллагуудын албан ёсны цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах журмыг шинэчлэн боловсруулж, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх.</b></p> <p>Аймгийн Засаг даргын 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/304 дугаар захирамжаар “Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч барагдуулах шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээллэх журам”-ыг шинэчлэн журамд иргэдийн өргөдөл, гомдлыг цахим хэлбэрээр хүлээн авах заалтыг оруулан батлуулж <a href="http://www.dundgovi.gov.mn">www.dundgovi.gov.mn</a> сайтад байршуулан Хэлтэс, агентлаг, сумдад санал хүсэлт хүлээн авах нээлттэй утсыг тогтмол ажиллуулж иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Тус аймгийн нийт төрийн байгууллага, 15 сумд иргэдээс санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг бичгээр, цахимаар, утсаар, хайрцагаар, биечлэн уулзах хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэж хэвшсэн. 2021 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 25,779 өргөдөл бүртгэснээс 25,609 өргөдлийг хуулийн хугацаанд судлаж 99,3 хувийн гүйцэтгэлтэй шийдвэрлэлээ. Аймаг, сумдын Засаг дарга нар Бямба гараг бүр 11:00-17:00 цагт иргэдтэй тусгайлан уулзалт хийж, иргэдийн санал бодлыг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэж байна. Иргэдээс санал, хүсэлт хүлээн авах бүх сувгийг идэвхжүүлсэн хэдий ч иргэдээс утсаар, бичгээр ирүүлсэн санал, хүсэлт нийт өргөдлийн 94,9 хувийг эзлэж байна. Агентлаг, сумдад санал хүсэлт хүлээн авах нээлттэй утас тогтмол ажиллуулж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газар 7059-106 утсаар иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, тус нээлттэй утсыг цахим сайт, фэйсбүүк хуудас, мэдээллийн самбар г.м бүхий л хэлбэрээр иргэдэд сурталчилж байна. Мөн сумдад IP технологид суурилсан, иргэд цээжлэхэд хялбар дугаар бүхий утсыг тогтмол ажиллуулж байна.</p> <div data-bbox="1342 1086 1522 1344" style="border: 1px solid black; padding: 5px;"> <p style="text-align: center;"><b>СУМДЫН ИРГЭДЭЭС СОНГОХ НЭЭЛТТЭЙ УТАС</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Аавал - 7097-8787</li> <li>2. Батмөрөгөн - 7097-9911</li> <li>3. Говь-Уртан - 7097-8392</li> <li>4. Гурвасалан - 7095-4949</li> <li>5. Дэлгэрсүет - 7099-4611</li> <li>6. Дэлгэрсүет - 7097-9999</li> <li>7. Дэрж - 7099-8787</li> <li>8. Луус - 7099-9999</li> <li>9. Овоон - 7093-7999</li> <li>10. Фендралан - 7099-2636</li> <li>11. Сайхан-Овоо - 7099-4999</li> <li>12. Сайнцагаан - 7093-9999</li> <li>13. Хулд - 7093-4949</li> <li>14. Цагаандал - 7097-9999</li> <li>15. Эрдэнэдалай - 7099-9999</li> </ol> </div> <p style="text-align: right;"><b>100%</b></p>
<p><b>Гурав. Төсөв, санхүү, аудитын ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай,</b></p>	<p><b>Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, хариуцлагыг дээшлүүлэх.</b></p> <p>Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2020 оны үндсэн хөрөнгийн тайланг нийт 142 байгууллагаас хүлээн авч, санхүүгийн тайлан баланстай тулгалт хийн баталгаажуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт цахимаар хүргүүлсэн. Орон нутгийн өмчийн 22 байгууллагын 143 төрлийн</p>	

**зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр**

ашиглалтгүй барилга байгууламжийг иргэн, хуулийн этгээдтэй түрээсийн гэрээг байгуулан түрээсээр эзэмшүүлэн орлогын 30 хувийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлж, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой нийт 39 тогтоол гарч үүнээс 6 байгууллагын ашиглалтгүй байгаа 8 тээврийн хэрэгсэл, 2 үл хөдлөх хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдаж, 6 байгууллагын 429.7 сая төгрөгийн балансын үнэтэй, 7 ширхэг ашиглалтгүй хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад балансаас баласад шилжүүлэн, 16 байгууллагын 2.5 тэрбум төгрөгийн балансын үнэтэй, элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон 156 нэр төрлийн 5393 ширхэг хөрөнгийг акталж, устгах тухай тогтоол гарган хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.



**100 хувь**

**“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” түүний хавсралт болон дэд цэсүүдэд тавигдсан мэдээлэл, түүний агуулга нь олон нийтэд ойлгомжтой байх.**

Шилэн дансны мэдээллийг иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар сурталчлан таниулах ажлын хүрээнд аймгийн вэб хуудас [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn) сайтын нүүрэн хэсэгт Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дүгээр заалтын мэдээллийг бүрэн байршуулсан. Тайлант хугацаанд шилэн дансны тухай хуулийн дагуу орон нутгийн өмчит төсвийн байгууллага, ОНӨҮГ-ын 142 байгууллага тогтоосон хугацаанд байршуулах нийт 18912 мэдээллээс 86.4 хувь буюу 16340 мэдээлийг хугацаанд нь, 6.5 хувь буюу 1230 мэдээллийг хугацаа хожимдуулж, нийт мэдээлэх мэдээний гүйцэтгэл 90.2 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжлээ.

[www.dundgovi.mn](http://www.dundgovi.mn) сайтын нүүрэн хэсэгт Шилэн дансны мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй байршуулан сурталчилж, иргэдийн хандалтыг нэмэгдүүлэх ажлыг улирал бүр зохион байгуулан сурталчлан таниулах ажлыг Санхүүгийн хяналт, аудитын албанаас зохион байгууллаа.

**100 хувь**

**Гадаад зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох, мэдээллийг сайжруулах.**

Эрчим хүчний яамнаас “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”, Азийн хөгжлийн банкны хөрөнгөөр аймгийн төвд цэвэрлэх байгууламжийн ажил, Эрдэнэдалай сумын усан хангаж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажил, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд 6 аймагт хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн Хөгжлийн төвийг барих, Япон Улсын Засгийн газрын 2021 оны Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хүрээнд “Дундговь аймгийн Сайнцагаан сумын 3-р цэцэрлэгийн засвар”-ын ажлын Дэлхийн банкны санхүүжилттэй “Эрчим хүчний төсөл-2” ажлын хүрээнд БЗӨБЦТС ТӨХК-ийн харьяа Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбарт хэрэгжүүлэх “Дундговь аймгийн төвийн 6кВ ба 0.4кВ хүчдэлийн түгээх сүлжээг шинэчлэх, цахилгаан хангамжийг сайжруулах ажил”-ын угсралтын ажил, Зах зээл бэлчээрийн удирдлага хөгжил төслийн хүрээнд аймгийн төвд хүнсний ногооны зоорь, өвс, тэжээлийн агуулах саравч, борлуулалтын цэгийн барилгын угсралтын ажил зэрэг хийгдэж буй төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл, түүний хэрэгжилт, явцын мэдээллийг тухай бүрт [dundgovi.gov.mn](http://dundgovi.gov.mn) сайтны Ил тод байдал хэсгийн төсөл хөтөлбөр талбарт байнга байршуулан иргэд, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

**100 хувь**

**Хувь хүн, хуулийн этгээдээс төсвийн байгууллагад өгсөн хандив, тусламж гэх мэт төсвийн бус орлого, түүний зарцуулалтыг мэдээлэх.**

Дундговио ногооруулъя хөтөлбөрийн хүрээнд сумдад дэмжлэг үзүүлэх, Малчдад туслах, Хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх хүрээний хандив тусламжийг Засгийн газрын 2014 оны 12 сарын 15-ны өдрийн 384-р дугаар тогтоолын хавсралт “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 4 дэх зүйлийн 4.1.8 дэх заалт “Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт”-ын хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор “хагас жил оруулах мэдээлэл” хэсэгт хугацаанд нь байршуулав.

**100 хувь**

**Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах.**


Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлгүүдийг зохион байгуулан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний саналыг иргэд, олон нийтээс авч, Төсвийн тухай хууль болон ОНХСангийн журамд нийцэж байгаагаар жагсаалт үүсгэж аймгийн ИТХ-д өргөн барьж, 2021 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 2021 оны төсвийн тодотголоор шинэчлэн батлуулж, нийт 44 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөснөөс 43 төсөл арга хэмжээний гэрээ хийгдээд байна.

Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн хөрөнгө оруулалтаар нийт 32 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөснөөс 29 төсөл арга хэмжээний гэрээ хийгдээд байна

**100 хувь**

**Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын [www.iltod.mn](http://www.iltod.mn), [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn), [www.shilendans.com](http://www.shilendans.com) цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх.**

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 43 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн явцын мэдээллийг [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn), [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайтад сар бүр байршуулан ил тод мэдээлэх ажлыг хэвшүүлсэн.



**100 хувь**  
**Аудитын байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.**

Төрийн Аудитын газраас тавигдсан актын төлбөр болох албан хаагчдын биеэр эдлээгүй амралтын хоногт ногдох урамшууллыг дундаж цалин хөлснөөс тооцож 3,060,997 төгрөгийн урамшууллыг илүү олгосон актын төлбөрийн 2,327,213 төгрөгийг, орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэн үлдэгдэл төлбөрийг холбогдох албан хаагчид төлөхийг шаардан албан бичиг хүргүүлэн ажиллаж байна. Мөн хяналтын тооллого хийх явцад бараа материалын тайлангийн үлдэгдэлд тайлагнасан 3,600,000 төгрөгийн дутагдсан номны төлбөртэй холбоотой асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар өгснийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгаж байна.

**70 хувь**  
**Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлж, хууль бус шийдвэрийг хүчингүй болгох.**

Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлын судалгаанд 37 албан тушаалтантай холбоотой 135,133.5 мянган төгрөгийн хохирол үүссэн байсан. Эдгээр албан тушаалтантай холбоотой албан шаардлагын хэрэгжилтийг хангахын тулд аймгийн Прокурорын газартай хамтран ажиллалаа. “Захиргааны ерөнхий хууль”-ийн 103.2 дах заалтыг үндэслэн хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх гэсэн боловч шийдвэр нь 2015-2016 оны 7 дугаар сараас өмнө гарсан ба уг хууль нь 2018 оны 7 дугаар сарын 01-ээс мөрдөгдөж эхэлсэн тул 2015, 2016 оны нэхэмжлэхүүдийг шүүхэд нэхэмжлэх боломжгүй болсон. Иймээс холбогдох тус тусын байгууллагууд нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь үндэслэн нэхэмжлэх эрх нь үүсч байгаа тул 30 албан тушаалтантай холбоотой 113,350.6 мянган төгрөгийн зөрчлийг буцаасан. Үлдсэн 7 албан хаагчтай холбоотой 21,782.9 мянган төгрөгийн зөрчлийг барагдуулах ажлыг зохион байгуулсан ба 6 албан тушаалтантай холбоотой 19,767.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар аймгийн Прокурорын газарт хүсэлт өгсөн. Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаяртай холбогдох авлага болох 3,019.5 мянга төгрөгнөөс 2,015.0 мянган төгрөгийг барагдуулан 1,004.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд 2019 онд үүссэн Сайнцагаан сумын I цэцэрлэгийн туслах багш Л.Батцэцэгтэй холбоотой 4,024.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар Прокурорын газарт хүсэлтийг хүргүүллээ.

**.30 хувь**


**Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг**

**Худалдан авах үйл ажиллагааны тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх.**



**боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, илтөд, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр**

Тендер шалгаруулалт улсын хэмжээнд 2017 оноос хойш tender.gov.mn цахим системээр цахим хэлбэрээр зохион байгуулах боломжтой болсон бөгөөд Дундговь аймагт 2018 оноос хойш төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа бүх байгууллагууд бүх тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зарлан зохион байгуулж байна. Цахим тендерийн давуу тал нь оролцогч цаг хугацаа, орон зайн хамааралгүй тендерийн урилга, тендерийн баримт бичиг, шалгуур үзүүлэлт, худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ажлын зураг, төсөв, техникийн тодорхойлолтыг үнэ төлбөргүй татан авах боломжоор хангагдаад байна. Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд 2021 оны 11 дүгээр сарын байдлаар дахин зарласан тендерийг оролцуулан нийт 284 тендер шалгаруулалт зохион байгуулсанаас Орон нутгийн өмчийн газарт 70 тендер зарлан зохион байгуулагдсан.



**100 хувь**

**Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байрлуулж, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулж, шалгаруулалтын талаар гарсан гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байх.**

Тендер шалгаруулалт зуун хувь цахим хэлбэрт шилжсэнтэй холбоотойгоор тендерт оролцогчийн шалгарсан болон шалгараагүй талаарх мэдээллийг tender.gov.mn системийн “Тендер шалгаруулалтын үр дүн” хэсэгт тухайн бүр үндэслэлийн хамт оролцогчид хүргэгдэж буй хариу мэдэгдлийн хуулбарыг оруулан ажиллаж хэвшээд байгаа бөгөөд оролцогчид ч шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендерийг хянах боломжоор бүрэн хангагдсан.

**100 хувь**


**Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулах.**

2020 худалдан авах ажиллагааны тайлан, Мандалговь хотын 5, 9, 12, 13-р байрнуудын гадна тохижилт, тоглоомын талбайн ажил, 5, 12-р байрны фасадны ажил, аймгийн төвийн авто замын засвар, хурд сааруулагчийн ажил болон Эрдэнэдалай сумын ЗДТГ-ын барилгын засварын ажлуудад хийсэн дотоод аудитын тайланг dundgovi.gov.mn сайтын Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаа хэсэгт зөвлөмжийн хэрэгжилттэй тус тус тайлагнаж мэдээллийг байршуулсан.

**100 хувь**

**Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх.**

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэх цахим сургалтыг 2021 оны 3 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Худалдан авах ажиллагааны сургалт зөвлөгөө өгөх төв ТББ-тай хамтран 161 хүнд зохион байгуулсан бөгөөд тус



сургалтаар хамрагдсан 161 хүн цахим шалгалтанд орж 48 хувь буюу 78 хүн тэнцэж, нийт сертификат эзэмшигчийн тоо 187 болж, худалдан авах ажиллагаанд иргэд, ТББ-ын төлөөллийг оролцуулж буй үр дүн гарсан.

**70 хувь**

**Сум, байгууллагуудын ЭБАТ-нуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулах.**

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн захиргааны болон Нутгийн захиргааны байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий 49 албан тушаалтнуудыг оролцуулан дараах сэдвүүдээр зохион байгуулав. Үүнд:



- “2021 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа, түүний онцлог”
- “2020 оны ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх, цахим системд баталгаажуулах тухай”
- “ЭБАТ-ны үйл ажиллагаа, мэдүүлэг гаргагчийн хамрах хүрээ, ХАСХОМ-ийн тайлан мэдээ гаргахад анхаарах зарим асуудал”
- “Мэдүүлгийн цахим систем ашиглалт”

**Тав. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг ажиллагааг сайжруулах зорилтыг чиглэлээр**

Төвийн 2 Эрх бүхий албан тушаалтнаас салбарын 49 ЭБАТ-уудыг чадавхжуулах сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулан тэдэнтэй ярилцлага зохион байгуулан асуусан асуулт, саналыг сонсож 100 хувь шийдвэрлэв.

**100 хувь**

**ХАСУМ болон хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргах үүрэг бүхий албан тушаалтны хамрах хүрээг эрхлэх албан тушаалынх нь онцлог, шийдвэр гаргах эрх мэдэл, улсын өмчтэй харьцах үйл ажиллагаа зэрэг авлигад өртөх эрсдэлийг харгалзан оновчтой тогтоох.**

Аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумын ИТХ, ЗДТГ-аас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах 564 этгээдийн нэрсийг батлагдсан маягтын дагуу эрхэлж буй албан тушаал, ажлын чиг үүрэг, регистрийн дугаар, албан тушаалын ангилал зэрэглэлийг нэг бүрчлэн тодорхойлон гаргаж Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлэн, мэдүүлэг гаргах үүрэг бүхий жагсаалтыг иргэд, олон нийтэд ил тод нээлттэй сурталчилан таниулах ажлыг зохион байгуулав.


Төрлийн ангилал	Төрлийн ангилал	Төлөв	
		Хүчин төгөлдөр	Хүчин төгөлдөр биш
А. Төрийн өмч	1	1	0
Б. Хувийн өмч	2	1	0
В. Хувийн өмч	3	1	0
Г. Хувийн өмч	4	1	0
Д. Хувийн өмч	5	1	0
Е. Хувийн өмч	6	1	0
Ж. Хувийн өмч	7	1	0
З. Хувийн өмч	8	1	0
И. Хувийн өмч	9	1	0
Й. Хувийн өмч	10	1	0
К. Хувийн өмч	11	1	0
Л. Хувийн өмч	12	1	0
М. Хувийн өмч	13	1	0
Н. Хувийн өмч	14	1	0
О. Хувийн өмч	15	1	0
П. Хувийн өмч	16	1	0
Р. Хувийн өмч	17	1	0
С. Хувийн өмч	18	1	0
Т. Хувийн өмч	19	1	0
У. Хувийн өмч	20	1	0
Ф. Хувийн өмч	21	1	0
Х. Хувийн өмч	22	1	0
Ц. Хувийн өмч	23	1	0
Ч. Хувийн өмч	24	1	0
Ш. Хувийн өмч	25	1	0
Щ. Хувийн өмч	26	1	0
Ъ. Хувийн өмч	27	1	0
Ь. Хувийн өмч	28	1	0
Э. Хувийн өмч	29	1	0
Э. Хувийн өмч	30	1	0
Ю. Хувийн өмч	31	1	0
Я. Хувийн өмч	32	1	0
Я. Хувийн өмч	33	1	0
Я. Хувийн өмч	34	1	0
Я. Хувийн өмч	35	1	0
Я. Хувийн өмч	36	1	0
Я. Хувийн өмч	37	1	0
Я. Хувийн өмч	38	1	0
Я. Хувийн өмч	39	1	0
Я. Хувийн өмч	40	1	0
Я. Хувийн өмч	41	1	0
Я. Хувийн өмч	42	1	0
Я. Хувийн өмч	43	1	0
Я. Хувийн өмч	44	1	0
Я. Хувийн өмч	45	1	0
Я. Хувийн өмч	46	1	0
Я. Хувийн өмч	47	1	0
Я. Хувийн өмч	48	1	0
Я. Хувийн өмч	49	1	0
Я. Хувийн өмч	50	1	0
Я. Хувийн өмч	51	1	0
Я. Хувийн өмч	52	1	0
Я. Хувийн өмч	53	1	0
Я. Хувийн өмч	54	1	0
Я. Хувийн өмч	55	1	0
Я. Хувийн өмч	56	1	0
Я. Хувийн өмч	57	1	0
Я. Хувийн өмч	58	1	0
Я. Хувийн өмч	59	1	0
Я. Хувийн өмч	60	1	0
Я. Хувийн өмч	61	1	0
Я. Хувийн өмч	62	1	0
Я. Хувийн өмч	63	1	0
Я. Хувийн өмч	64	1	0
Я. Хувийн өмч	65	1	0
Я. Хувийн өмч	66	1	0
Я. Хувийн өмч	67	1	0
Я. Хувийн өмч	68	1	0
Я. Хувийн өмч	69	1	0
Я. Хувийн өмч	70	1	0

**100 хувь**


**Мэдүүлгийг цахим хэлбэрээр авах тогтолцоонд бүрэн шилжүүлэх.**



		<p>сайтны нүүрэн хэсгийн Авлигын эсрэг үйл ажиллагаа хэсэгт ил тод байршуулж, сум, байгууллагууд удирдах албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдол бүрт шинэчилж байхыг ЭБАТ-нуудад зөвлөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p>
<p><b>Арав. Шударга ёсны үзэл төлөвшүүлэн, нийтийг гэгээрүүлэх ажиллагааг үе шаттай зохион авлигын боловсролыг дээшлүүлэх хангах чиглэлээр</b></p>	<p><b>Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах</b></p>	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг аймаг, сумдын ЭБАТ болон Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн сургагч багш нар хамтран иргэд, олон нийт, хүүхэд багачуудад цахим хэлбэрээр хүргэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг сургалт, сурталчилгаа зохион байгуулах сургагч багш бэлтгэх анхан шатны сургалтад аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗСЗ-ийн нарийн бичгийн дарга, сумдын ИТХ, сургалт хариуцсан хамрагдаж бэлтгэгдсэн. Бэлтгэгдсэн сургагч багш нар болон аймгийн ИТХ, ЗДТГ, ГХУСАЗСЗ хамтран нөөц бололцоогоо ашиглан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 5 хэлтэс, агентлаг, 5 сумын төрийн албан хаагч, иргэд, сурагчдад, сумдын ГХУС салбар зөвлөлийн гишүүд зэрэг нийт 16 нэгжийн 446 хүнд Авлига, авлигын шалтгаан, нөхцөл, хор хөнөөл, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжоор сургалтуудыг зохион байгуулан, сургалтын үеэр суралцагчдыг багт хуваан кэйс ажиллуулан мэдлэгийг зохих түвшинд бататгаж үр дүнг тооцов.</p> <p>Олон улсын авлигын эсрэг өдөрт зориулан хүүхэд залуучууд, иргэд, олон нийтийн дунд “Тик ток” уралдаан, төрийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын дунд “АХА” тэмцээнийг зохион байгуулан “Шударга ёс”-ыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудаас зохион байгуулсан бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж түгээн дэлгэрүүлж сурталчлан таниуллаа.</p> <p>Шударга ёсны үнэ цэнэ, Авлигын эсрэг олуулаа нэгдье, Гэрэл тусгая Зш, Арын хаалга, Албаны мэдээллээ аминдаа, Гайтай бэлэг, Танилын гуйлт, Авлигын шилэн бөмбөлөг, Авлига хожихгүй нүүдэл, Төрийн албан хаагч танаа 1, 2; 110 дугаарын сурталчилгаа 1, 2, 3 шторкуудыг Дундговь аймгийн <a href="http://www.dundgovi.gov.mn">www.dundgovi.gov.mn</a> сайт; аймгийн ИТХ-ын цахим хуудас <a href="http://www.khural.mn">www.khural.mn</a>, Онцгой байдлын газрын дэргэдэх Лед дэлгэц, Дундговь аймгийн ЗДТГ таныг сонсож байна, “Дундговь Эрх зүйн хөтөч” пэйж хуудсууд болон сум, байгууллагуудын сайт, пэйж хуудсуудаар; АВЛЕ.mn программын Олон нийт хэсгээр, байгууллагуудын үүдний хэсэгт байрладаг “Цахим мэдээллийн дэлгэц” зэргээр төрийн албан хаагч болон иргэдэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, 15409 хүний хандалттай бөгөөд 451 хүн share хийсэн байна.</p> <p><b><u>Хэвлэн олшруулж байрлуулах материал</u></b></p>



Авлигын эсрэг хуулийг сурталчилсан 6 төрлийн тараах материал болох 110 дугаарын сурталчилгаа, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд хориглох зүйл, Авлигын хэлбэрүүд, Авлигын болон хуулийн холбогдох заалтуудаас, Авлигын тухай мэдэгдэх сурталчилгааны материалыг сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг болон иргэд, олон нийтэд 450 ширхэгийг өнгөтөөр хэвлэн олшруулан хүргүүлж, цаашид сум, байгууллагуудыг олшруулан иргэд, албан хаагчдад түгээхийг аймгийн Засаг даргаас үүрэг болгон албан бичгээр хүргүүлсэн. Сум бүрт видео контент, шторк, CD зэргийг тусгайлан хүргүүлж, сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа.



**Арван нэг: урьдчилан чиглэлээр байгуулсан ажил**

**Авлигаас сэргийлэх зохион шинэлэг**

**100 хувь Төрийн байгууллагын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах.**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020-2023 оны аймгийн төлөвлөгөөг 8 бүлэг, 34 зүйлтэй боловсруулан батлуулж, сум, байгууллагуудад хүргүүлэн, [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn) сайт, и-монголия программаар иргэд олон нийт, төрийн албан хаагчдад сурталчлан таниуллаа. Аймгийн төлөвлөгөө, тайлан, зохион байгуулсан үйл ажиллагаатай холбоотой мэдээлллийг [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn) сайтны Ил тод байдал хэсгийн Авлигатай тэмцэх үйл ажиллагаа хэсгийн төлөвлөгөө, үйл ажиллагаа, ХАСУМ хянуулсан дүгнэлт хэсгүүдэд тус тус байршуулан сурталчилж хэрэгжилтийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн .хуралдаанаар хэлэлцүүлэн үнэлүүлж, Тэргүүлэгчдийн олонхийн саналаар тус хөтөлбөрийн хэрэгжилтийг 88.7 хувиар үнэлэгдэж, үнэлсэн шийдвэрийг нотлох баримтаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.

БАТЛАВ  
2021 оны 12 сарын 23-ны өдөр  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА /.../

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГ БАРИМТАА

Төрийн захиргааны байршил	№	Үйл ажиллагааны нэр	Хэрэгжүүлсэн хувиар	Эцэс үүсгэвч	Төлөвлөгөөний үнэмлэхүй үзүүлэлт	Хэрэгжилтийн үр дүнгийн үзүүлэлт	Төлөв	Түрээс	Хяналтын
1. ИТХ	1	Төрийн захиргааны байршилд авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээлллийг таниулах	88.7%	Төрийн захиргааны байршилд авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээлллийг таниулах	100%	88.7%	Хэрэгжүүлсэн	Төрийн захиргааны байршилд авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээлллийг таниулах	Сум байгууллагуудад авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээлллийг таниулах



**70 хувь Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн албан хаагч болон иргэд, олон нийтэд зориулан тодорхой шинэлэг ажил, арга хэмжээг зохион байгуулах.**

Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх зорилгоор “Зөв зөвд шударга зөв” сэдэвт соён гэгээрүүлэх аяныг аймгийн ИТХ болон Засаг дарга түүний ажлын алба, ЗДТГ, сумдын ЗДТГ, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг бүр зохион байгуулан ажиллалаа. Аймгийн ИТХ-ын дарга, аймгийн

Засаг дарга нар аяны хүрээнд 15 ажил, арга хэмжээг төлөвлөн баталж шударга ёсыг түгээн дэлгэрүүлэх олон төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. “Зөв зөвд Шударга зөв” аяны



хүрээнд “Дундговь авлигагүй хөгжинө” уриалгыг хэрэгжүүлэн авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах-110 дугаарыг сурталчлах, хүүхэд, залуучуудын дунд “Тик ток”, “Гар зураг”-ын уралдаан, Сайн найзууд байцгаая-110”

хөдөлгөөнийг тус тус өрнүүлэн, төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын дунд Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль, Төрийн албаны болон бусад хууль тогтоомж, танин мэдэхүй сэдвээр “АХА” уралдаант тэмцээнийг тус тус зохион байгууллаа. Авлигын эсрэг тв шторк, инфографик, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудсыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгууллаа.



**100 хувь “Дундговь авлигагүй хөгжинө” уриалгыг хэрэгжүүлэн, авлигын эсрэг ОУ-ын өдрийг иргэд, албан хаагч, ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулан, авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг сурталчлах.**

“Шударга ёс, хөгжил дэвшилд-110” дугаарын самбарыг төрийн байгууллагууд ажиллуулан, авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг

стикерийг Олон үүдэн авлигагүй хөгжинө” уриалгын хамт байнга



сурталчилсан аймгийн ЗДТГ-ын нийттэй харилцах хэсэгт “Дундговь

байршуулан сурталчиллаа. Уг уриалгыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг дарга, ХХҮГ-ын дарга нар санаачлан төрийн албан хаагчдын оролцоотой “Шударга ёс, хөгжил дэвшилд-110 дугаарыг олон нийтэд хүрээ






иргэдийн

дугаарыг тэтгэмжинд хамрагдах



хэлбэрээр сурталчилж, мэдэх эрхийг дээшлүүлсэн. Уг Хүүхдийн мөнгөн хэрхэн видео бичлэгт,

		<p>амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдэд зориулсан гарын авлагын хавтсанд, “Малчин өрхийн орлого зарлагын дэвтрийн хөтөлгөө” зэрэг нийт 328ш, 5 сумын ЕБС-ийн сурагчдад “Сайн найзууд байцгаая-110” наалтыг 150ш, ТАХ-чдын өрөөний хаалганд “Тат түлх” хэлбэрээр 15 сумын (ГХУС салбар зөвлөлд) 150 ш түгээн дэлгэрүүлсэн.</p>	<b>100 хувь</b>
<p>9. Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>		<p>-Аймгийн ИТХ-ын дарга болон аймгийн Засаг даргаас аймгийн ИТХ-ын төлөөлөгч, хэлтэс, агентлагуудын удирдлагуудыг уриалан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх <b>“Дундговь авлигагүй хөгжинө”</b> уриалгад нэгдэв.</p> <p>-Аймгийн хэмжээний Нийтийн албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдүүдийн ажил эрхлэлтийн судалгааг <a href="http://www.dundgovi.gov.mn">www.dundgovi.gov.mn</a> сайтад ил тод сурталчилсан нь иргэдээс удирдлагуудын томилгоонд хяналт тавих нөхцлийг бүрдүүлэв. Уг судалгааг Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалтаар ХАСУМ хянуулахад хэрэгтэй, ажил хэрэгч асуудал гэж үзэн улсын хэмжээнд туршлага болгон хэрэгжүүлсэн. Тус судалгааг аймгийн <a href="http://www.dundgovi.gov.mn">www.dundgovi.gov.mn</a> сайтны Ил тод байдал хэсгийн Авлигатай тэмцэх үйл ажиллагаа хэсэгт ил тод байршуулан, сум, байгууллагууд удирдах албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдол бүрт шинэчилж байхыг зөвлөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>-ХАСУМ хянуулсан дүгнэлт /албан бичиг/-ийг аймгийн <a href="http://www.dundgovi.gov.mn">www.dundgovi.gov.mn</a> сайтны Ил тод байдал хэсгийн Авлигатай тэмцэх үйл ажиллагаа хэсгийн ХАСУМ хянуулсан дүгнэлт хэсэгт тухай бүр байршуулан сурталчилдаг. Тус хэсэгт тус оны буюу 2021 оны 12 дугаар сарын 09-нийг угтсан “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд хийгдсэн ажлын тайлан, Авлигатай тэмцэх газарт дүгнэгдэх хуудасны хамт байршуулан сурталчилсан.</p> <p>-Монгол Улсын Аж үйлдвэрийн гавъяат, сэтгүүлч С.Пүрэвсүрэнгээр төрийн албан хаагчдыг авлигагүй-шударга, хүнд сурталгүй ажиллахыг уриалсан богино хэмжээний уриалга, Хүүхэд, залуучуудад зориулсан, уриалсан нөлөөллийн ТВ шторкийг Хөдөлмөр, үйлчилгээний хамтран бэлтгэж болон Хөдөлмөр, үйлчилгээний газрын хуудсуудаар сурталчиллаа.</p> <p>-Улсын болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажлын гэрээ байгуулсан компаниудыг авлигын эсрэг уриалгад уриалж, сурталчилгааны самбарт уриалгын үг бичүүлэн ажиллуулав.</p> <p>-Тендер шалгаруулалтын үнэлгээний хороо хуралдах бүртээ үнэлгээний хорооны гишүүдийг авлигын эсрэг уриалсан энгэрийн тэмдэг хэрэглэж хэвшүүлснээр, тендерийг шударгаар үнэлж шалгаруулах орчныг бүрдүүлэв.</p>	   <p>халамж газартай аймгийн халамж цахим</p>

		<p>-Төрийн үйлчилгээг илүү хурдан, хөнгөн шуурхай, ил тод нээлттэй явуулах зорилготой “erp.e-mongolia.mn” програмыг аймаг, сум, хэлтэс, агентлагууд бүрэн ашиглаж мэдээ, мэдээллийг түргэн шуурхай солилцдог болсон нь ажлын бүтээмж сайжирч, ажил хөнгөвчилсөн зэрэг олон давуу талыг бий болгосон үр дүнтэй арга хэмжээ болж байна.</p> <p>-Аймгийн Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн 2018 оны 16 дугаар хурлаар “Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, гэрээний төслийг хянах, баталгаажуулах, сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нарын баталсан эрх зүйн актыг хянах, зөвлөх журам”-ын хоёрдугаар хавсралтаар батлагдсан Захиргааны актад санал өгч, хянах албан тушаалтнууд “Ашиг сонирхлын зөрчилтэй, зөрчилгүй эсэхээ илэрхийлэхийг зааж өгсөн.</p> <p>-Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зурагт хуудас, шторк, FM радиогийн зөвлөгөө, мэдээллийг аймаг, сум, байгууллагуудын сайт, пэйж хуудсуудаар иргэд, олон нийтэд хүргэх ажлыг аймаг, сум, хэлтэс, агентлагуудын Эрх бүхий албан тушаалтнууд болон хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан бүр оролцож олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан.</p>
10.	Санал	<p>-Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улс, орон нутгийн төсвөөс хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллахыг анхаарах.</p> <p>-Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээр ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн тохиолдолд буруутай албан тушаалтнаас хохирол барагдуулах ажлыг эрчимжүүлэх.</p> <p>-Авлигатай тэмцэх газрын болон Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлж ажиллах. (Төрийн жинхэнэ албан хаагчийн томилгоог хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, иргэд, олон нийтийн хяналтыг сайжруулах)</p> <p>-Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах.</p> <p>-Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн эргэн төлөлт, зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьж, олгосон зээл, түүний талаарх мэдээллийг ил тод болгон сонирхогч этгээд ойлгох хэлбэрээр танилцах боломж, нөхцөлийг бүрдүүлэх.</p>
11.	Шаардагдах төсөв	10.000.000
12.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>-Аймгийн ЗДТГ-ын Эрх бүхий албан тушаалтан буюу авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, соён гэгээрүүлэх сургалт сурталчилгааны ажилтныг орон тооны болгох.</p> <p>-Худалдан авах ажиллагаанд байнгын хяналт тавьж, АЗ сертификатын сургалтыг үнэ төлбөргүй, ялангуяа иргэд, ТББ-ын төлөөллийг үнэ төлбөргүй сургалтанд өргөн хүрээгээр оролцуулж, үнэлгээний хороонд тогтмол ажиллуулах.</p> <p>-Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэгч сургагч багш нарыг иргэд, төрийн албан хаагчдад авлигатай тэмцэх, түүнээс</p>



		урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажлыг ЭБАТ-нуудтай хамтран зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.					
13.	Сургалтад хамруулах албан хаагчийн тоо	518					
14.	Бүх шатны төрийн байгууллагад хамаарах						
	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж 88.7	Зорилтын тоо 8	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
83.3%				80.0%	87.5%	92.5%	
15.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	88.7	8	Зорилт 5	Зорилт 7	Зорилт 10	Зорилт 11
				100.0%	100.0%	100.0%	90.0%
18.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ					
		88.7					

ХЭРЭГЖИЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН:  
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН /С.ЦЭНГЭЛМАА/

ХЯНАСАН: АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Л.ДОРЖБАТ/